



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/118

Баян-Өндөр сум

**Г Түрээсийн төлбөрийн хэмжээ Г
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, "Түрээсийн төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 14/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эзэмшлийн байр (спортын заал, танхим, павильон), гадна талбайн түрээсийн төлбөрийн үнийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж, түрээсийн төлбөрийг төвлөрүүлэхдээ данснаас дансны хооронд болон цахим төлбөрийн систем ашиглах (бэлэн мөнгө ашиглахгүй, хувь хүний дансаар дамжуулахгүй байх)-аар төлөвлөн ажиллахыг ерөнхий нягтлан бодогч, аж, ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал), нярав (Т.Золзаяа) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тогтоол, шийдвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн (М.Ариун-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Биеийн тамир, спортын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/117 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

(D):BTSG-2024-Tushaal-2024
612401346

Биеийн тамир, спортын газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн
0118.....дугаар тушаалын хавсралт

БАЙГУУЛЛАГААС ҮЗҮҮЛЖ БУЙ ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТҮРЭЭСИЙН ҮНЭ, ТАРИФ

№	Үйлчилгээний төрлийн нэр		Х/н	Төлбөр		Тайлбар
				Байршил	1 цагийн хөлс	
1	Спортын заал, танхим	Өсвөрийн шигшээ баг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өвлийн спорт, ахмад настан	сард	А, Б заал	үнэ төлбөргүй	спортын төрөл, дасгалжуулагч багш, тамирчдыг байгууллагаас баталгаажуулж, гэрээ байгуулна.
2		Секц дугуйлан	1 цагийн	Б заал	20,000	гэрээ байгуулна.
				А заал	15,000	гэрээ байгуулна.
3		Байгууллага, аж ахуйн нэгжийн чийрэгжүүлэлт	1 цагийн	Б заал	40,000	гэрээ байгуулна.
				А заал	30,000	гэрээ байгуулна.
4		Бөхийн танхим	сардаа	Б заал	250,000	гэрээ байгуулна.
5		Ширээний теннисний танхим	сардаа	Б заал	250,000	гэрээ байгуулна.
6		Чөлөөт тоглолт	1цаг/1хүүхэд	А, Б заал	1,000	Qрау төлбөрт системээр төлнө
7	1цаг/талбай		Б заал	40,000		
8	1цаг/талбай		А заал	30,000		
9	Спортын тоног төхөөрөмж иж бүрдэл		жилд	жилийн үнийн дүнгийн 10%		гэрээ байгуулна.
10	Павильон	04-09-р саруудад	сардаа	Наадмын талбай	96,000	гэрээ байгуулна.
		10-03-р саруудад			35,000	гэрээ байгуулна.
11	тог, цахилгааны үнэ		өдрийн		5,000-10,000	гэрээ байгуулна.
12	Унадаг дугуй, скүүтэр, ролик		өдөрт/ш		1,000	гэрээ байгуулна.
13	Хүүхдийн машин		өдөрт/ш		2,000	гэрээ байгуулна.
14	Хийлдэг тоглоом	10м2-с дээш талбай	өдөрт/ш		5,000	гэрээ байгуулна.
		10м2-с доош талбай	өдөрт/ш		3,000	гэрээ байгуулна.